

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК



**“ЧИНГЭЛТЭЙ ХҮТ-ИЙН ШИНЭ ОФФИСИЙН ТАВИЛГА”  
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Тендерийн нэр: “Чингэлтэй ХҮТ-ийн шинэ оффисийн тавилга”  
Тендерийн дугаар: ХА-011/2020**

*Улаанбаатар хот - 2020 он*

## ЦАХИМ ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдөр  
Тендерийн нэр: “Чингэлтэй ХҮТ-ийн шинэ оффисийн тавилга”  
Тендерийн дугаар: ХА-011/2020

**“УБЦТС” ТӨХК** эрх бүхий тендерт оролцогчдоос: **“Чингэлтэй ХҮТ-ийн шинэ оффисийн тавилга”** нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендерийг **2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 09 цаг 30 минутад** тендерийн нээлтийн өрөөнд нээнэ. /УБЦТС ТӨХК-ийн төв байрны 206 тоот/

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Захиалагчийн хаяг:**  
**Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг. 3-р хороо,**  
**Чингисийн өргөн чөлөө-45.**  
**УБЦТС ТӨХК-ийн төв байр. 206 тоот.**  
**Хангамж үйлчилгээний алба**  
**Утас: 342420 +157, Факс: 976-341852**  
**Цахим хаяг: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**


6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ	
ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны санхүүгийн тайлан аудитаар баталгаажуулж ирүүлэх.</li> <li>2. Борлуулалтын орлого сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он тус бүрийн орлого санал болгож буй үнийн дүнтэй дүйцэхүйц.</li> <li>3. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл 2018, 2019 оны аль нэг жилд шинэ оффисийн тавилга нийлүүлж байсан туршлагатай байх, гэрээний хуулбар, бараа хүлээлцсэн акт, протокол ирүүлнэ.</li> </ol> <p><b><u>Нэмэлт шаардлага</u></b></p> <ol style="list-style-type: none"> <li>4. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга</li> <li>5. Улсын бүртгэлийн гэрчилгээ</li> <li>6. Үнийн саналыг маягтын дагуу ирүүлэх. Төсөвт өртөг /49,490,000 төгрөг/</li> <li>7. Бараа нийлүүлэлтийн хуваарь /Гэрээний дагуу/</li> <li>8. ШШГЕГ-ын тодорхойлолт</li> <li>9. Татварын тодорхойлолт /тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байна./</li> <li>10. Гэрээний үнэ, хугацаанд хийж гүйцэтгэж, хүлээлгэж өгөхийг баталсан албан мэдэгдэл ирүүлнэ.</li> <li>11. Тендерт оролцогч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ.</li> <li>12. Чанарын баталгаат хугацаа 6 сар</li> <li>13. Нийлүүлэх барааны зураг, үйлдвэрлэгчийн каталогийн эх хувийг ирүүлнэ. Каталог дээрээс санал болгож буй барааг ялган тодруулж ирүүлнэ. Гадаад хэл дээрх нийлүүлэх материалыг Монгол хэл рүү орчуулан ирүүлнэ.</li> <li>14. Олон улсын чанарын стандартын шаардлага хангасан эсэхийг гэрчлэх гэрчилгээ, сертификатыг хавсарган ирүүлнэ.</li> <li>15. Тендерийн баримт бичгийн 6,7 дугаар бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, тендерийн баримт бичгийн маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.</li> <li>16. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</li> </ol>

<p><b>ТӨӨЗ 2.1</b></p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:  <b>Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</b>  Харилцах утас: 976-11-342420+157, 158</p> <p>Байгууллагын хаяг: <b>Хан-уул дүүрэг 3-р хороо Чингисийн өргөн чөлөө-45, "УБЦТС" ТӨХК-ийн төв байр.</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>2-р давхар, 206 тоот өрөө</b>  Огноо: <b>2020 оны 03 дугаар сарын 19-ний өдөр</b>  Цаг: <b>09 цаг 00 минут</b></p> <p><b>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</b></p>
<p><b>ТӨӨЗ 2.1</b></p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Хан-уул дүүрэг 3-р хороо Чингисийн өргөн чөлөө-45, "УБЦТС" ТӨХК-ийн төв байр</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>[2-р давхар, 206 тоот өрөө]</b></p> <p>Огноо: <b>2020 оны 03 дугаар сарын 19-ний өдөр</b></p> <p>Цаг: <b>09 цаг 30 минут</b></p>
<p><b>ТӨӨЗ 2.3</b></p>	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. <b>[Тендерт оролцогчийг эрх бүхий болохыг нотлохтой холбоотойгоор ТШӨХ-д заасан бүх баримт бичгийг жагсаан бичих]</b></li> <li>2. ...</li> <li>3.</li> </ol>
<p><b>ТӨӨЗ 6.2</b></p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцгүй</b>  <b>ХА-011/2020 Чингэлтэй ХҮТ-ийн шинэ оффисийн тавилга</b></p>

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Техникийн тодорхойлолт шаардлага үзүүлэлт	Доорх зурагтай дүйцэхүйц
Сейф	ширхэг	1	Албан хэрэг хадгалах зориулалтын 75, 85 см-ийн хэмжээтэй электрон байх	
Том ширээ	ширхэг	3	8-10 хүний хурлын ширээ 2 м урт Тавцан болон хөл нь сайн чанарын шахмал модон хавтангаар тавцан зуйван байна, угсардаг байх.	
Сандал ажилчдын	ширхэг	60	Хөл нь сайн чанарын төмөр байна. Ажилчид суух зориулалттай сайжруулсан чийг татахгүй хиймэл гадаргуутай	
Дарга сандал	ширхэг	1	Хөл сайн чанарын мод байна. Сайжруулсан арьсан бүрээстэй, гарын тавиуртай байна.	
Сэтгүүлийн ширээ	ширхэг	1	Сэтгүүлийн ширээ тавцан болон хөл нь сайн чанарын шахмал модон хавтангаар хийсэн байна, угсардаг байх.	

Буйдан 3 хос	ширхэг	1	Стандарт хэмжээтэй 3 хос, модон рамтай, сайжруулсан арьсан бүрээстэй байна.	
Ширээ сандал	Хос	25	Оффисийн ажилтануудын ширээ 1.5 м урттай, сандал суудлын налах, суух хэсэг сайн чанарын материалаар хийгдсэн, 2 гарын тавиуртай, гарын тавиур их бие нурууны түшлэгтэйгээ бэхлэгдсэн салж хөдлөхгүй	
Ширээ /Хэрэглэгчдийг хүлээн авах танхимын/	ширхэг	7	Хэрэглэгчдийг хүлээн авах танхимын ажилтануудын чулуун тавцантай угсраа ширээ 4.8 м урттай 4 хүний, чулуун тавцантай угсраа ширээ 3.6 м урттай 3 хүний ширээ тус бүр тумбочкатай сайн чанарын материалаар хийгдсэн, угсардаг байх.	
Бичгийн шкафтай Хувцасны шкаф -24 ширхэг /бүгд төмөр/	ширхэг	24	Бичиг хэрэг хадгалах зориулалттай Инженер Техникийн Ажилчдын хувцас хадгалах 2м өндөр төмөр материалаар хийгдсэн, угсардаг байх.	

**Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь**

**Чингэлтэй ХҮТ-ийн шинэ оффисийн тавилга**

№	Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	Сейф		1	ширхэг	Чингэлтэй Хэрэглэгчдэд үйлчлэх төв	Гэрээний дагуу	Гэрээний дагуу	
2	Том ширээ		3	ширхэг	Чингэлтэй Хэрэглэгчдэд үйлчлэх төв	Гэрээний дагуу	Гэрээний дагуу	
3	Сандал ажилчдын		60	ширхэг	Чингэлтэй Хэрэглэгчдэд үйлчлэх төв	Гэрээний дагуу	Гэрээний дагуу	
4	Дарга сандал		1	ширхэг	Чингэлтэй Хэрэглэгчдэд үйлчлэх төв	Гэрээний дагуу	Гэрээний дагуу	
5	Сэтгүүлийн ширээ		1	ширхэг	Чингэлтэй Хэрэглэгчдэд үйлчлэх төв	Гэрээний дагуу	Гэрээний дагуу	
6	Буйдан 3 хос		1	ширхэг	Чингэлтэй Хэрэглэгчдэд үйлчлэх төв	Гэрээний дагуу	Гэрээний дагуу	
7	Ширээ сандал		25	Хос	Чингэлтэй Хэрэглэгчдэд үйлчлэх төв	Гэрээний дагуу	Гэрээний дагуу	
8	Ширээ /хэрэглэгчдийг хүлээн авах танхимын/		7	ширхэг	Чингэлтэй Хэрэглэгчдэд үйлчлэх төв	Гэрээний дагуу	Гэрээний дагуу	

9	Бичгийн шкафтай Хувцасны шкаф -24 ширхэг хувцасны шкаф-20 ширхэг /бүгд төмөр/		24	ширхэг	Чингэлтэй Хэрэглэгчдэд үйлчлэх төв	Гэрээний дагуу	Гэрээний дагуу	
	Нийт		<b>123</b>					

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Шалгах болон турших</b>                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| <b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| <b>5. Баталгаат засварын хугацаа</b>                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[6]</b> сар байна.   |
| <b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| <b>7. Төлбөр</b>  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д 90]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| <b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| <b>9. Алданги оногдуулах</b>                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| <b>10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах</b>        | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| <b>11. Маргааныг шийдвэрлэх</b>                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Барааг Санхүү бүртгэлийн хэлтсийн нярав, хангамж үйлчилгээний албаны мэргэжилтэн, холбогдох газрын инженер нарт шалгалт, туршилт хийн хүлээлгэж өгнө. Туршилтаар шаардлага хангахгүй барааг захиалагчийн төлөөлөгч хүлээн авахгүй байх эрхтэй.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ, туршилтын протокол
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага 6 сар байна.
- [Уг хугацаанд баталгаат засвар болон чанарын баталгаа болгон гэрээний үнийн дүнгийн 5 хувийн мөнгөн дүнг авч үлдэнэ.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[95]<sup>1</sup>** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичиг, гэрээ дүгнэсэн протоколыг үндэслэн 90 хоногийн дотор төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup> 9.1. Алданги оногдуулах хувь: **Үүргийн хугацаа хоцорсон хоног тутам гэрээний үнийн дүнгийн 0,1 хувь.**
- Алдангийн нийт дүн: **Гэрээний үнийн дүнгийн 10 хувь хүртэл байна.**

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

<sup>2</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;

<sup>3</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>4</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*